L3895/L3896/G9205(EF)-MON:
VEGETABLE PRODUCTION AND IRRIGATED AGRICULTURE PROJECT

Тендерийн урилга

Огноо: 2025 оны 6-р сарын 9-ний өдөр
Зээл/Буцалтгүй тусламжийн дугаар ба нэр: G9205-MON, Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл
Гэрээний дугаар ба нэр: G-11 Орон нутгийн ногоочдын бүлэгт зориулсан механикжуулалтын багц

Тендер хүлээн авах эцсийн хугацаа: 2025 оны 6-р сарын 30-ны өдөр

1. Монгол Улс нь Азийн хөгжлийн банк (АХБ)-аас Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төслийг санхүүжүүлэх зорилгоор энэхүү санхүүжилтийг хүлээн авсан бөгөөд уг хөрөнгөөр дээр дурдсан гэрээний төлбөрийг санхүүжүүлэх зорилготой болно. Тендер шалгаруулалт нь АХБ-ны эрх бүхий орны тендерт оролцогчдод нээлттэй байна.

2. Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (“худалдан авагч”) нь эрх бүхий тендерт оролцогчдоос орон нутгийн ногоочдын бүлэгт зориулсан механикжуулалтын багц худалдан авах тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

3. Нээлттэй өрсөлдөөнт дотоодын тендер шалгаруулалтыг АХБ-ны *нэг үе шаттай: нэг дугтуйт* горимын дагуу зохион байгуулах ба тендерийн баримт бичигт заасан эрх бүхий орны бүх тендерт оролцогчдод нээлттэй байна.

4. Энэхүү тендер шалгаруулалтад зөвхөн дор дурдсан чадварын үндсэн шаардлагыг хангасан эрх бүхий тендерт оролцогч оролцоно. Үүнд:

    a. Сүүлийн 3 (2022, 2023, 2024) жилийн хугацаанд нийт 856,740,000 төгрөгийн үнэ бүхий ижил төстэй ханган нийлүүлэх 1 гэрээний үндсэн ханган нийлүүлэгчээр ажиллаж байсан туршлагатай, амжилттай гүйцэтгэсэн байх
    b. Дараах санхүүгийн шаардлагыг хангасан байх ёстой:
        - Сүүлийн 3 (2022, 2023, 2024) жилийн хугацаанд гүйцэтгэсэн болон гүйцэтгэгдэж буй гэрээнүүдийн хүлээн авсан нийт төлбөрөөр тооцсон жилийн дундаж борлуулалтын доод хэмжээ 1,606,387,000 төгрөг байх
        - Тендерт оролцогчийн сүүлийн 3 (2022, 2023, 2024) жилийн санхүүгийн байдлын найдвартай байдал.

5. Дэлгэрэнгүй мэдээлэл авах болон тендерийн баримт бичигтэй танилцах сонирхолтой эрх бүхий тендерт оролцогч нь дараах хаягаар хандана:

   Байгууллагын нэр: Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл
   - Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө 18А/1, ХАА-н хоршоологчдын үндэсний холбооны байр, 5 давхар, 511 тоот
   - Цахим шуудан: vpia.procurement1@gmail.com
   - Утас:77113895
   -

6. Тендер ирүүлэх:

   - Тендерт оролцогчид нь төрийн худалдан авах ажиллагааны цахим системийг ашиглан (https://tender.gov.mn) тендерийг ирүүлнэ.
   - Тендер хүлээн авах эцсийн хугацаа: 2025 оны 6-р сарын 30-ны өдөр болон түүнээс өмнө Улаанбаатарын цагаар 10:00 (GMT+8)
   - Тендерийг тендерийн баримт бичигт заасан тендерийн баталгааны хамт тус тус ирүүлнэ.

Тендер хүлээн авах эцсийн хугацаа дууссаны дараа оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг цахим системээр нэн даруй нээнэ.